



НИЙГМИЙН ХАЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2015 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

Санхүүгийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор С.Энхзаяа
Утас: 261663
Цахим хаяг: enkhzayas@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Гүнжидмаа
Утас: 261885
Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Цэрэндорж
Утас: 261740
Цахим хаяг: tserendorjd@audit.gov.mn

ТАБ-ын хаяг: Үндэсний аудитын
газар

Байршил: Чингэлтэй дүүрэг
Цахим хуудас: www.audit.mn

2016 оны 3 дугаар сар

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Материаллаг байдлыг тодорхойлох:
6. Дотоод хяналт
7. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэлийн талаар
8. Шилэн дансны мэдээлэл
9. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
10. Гол, онцлог гүйлгээний талаар
11. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар
12. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар
13. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
17. Зөвлөмж
18. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаар санал дүгнэлт

Хавсралт 1: Аудитын гэрчилгээ

Хавсралт 2: Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

Хавсралт 3: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Хавсралт 4: Менежментийн захидал

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1, 18.2-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газрын 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд /ҮАГ-САГ/2016/4-СТА-ТТ3 / аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газрын 2015 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газрын 2015 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2016 оны 3 дугаар сарын 05-наас 2016 оны 3 дугаар сарын 25-ны хооронд хийхээр төлөвлөн Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Д.Цэрэндорж хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газрын 2015 оны санхүүгийн тайланг 2016 оны 3 дугаар сарын 04-ний өдрийн 1/198 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлснийг аудиторт 3 дугаар сарын 7-ны өдөр хүлээн авсан байна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газар нь санхүүгийн үйл ажиллагаандаа Монгол Улсын Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай болон бусад холбогдох хуулиуд, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, Сангийн сайдын 2006 оны 388, 2008 оны 352 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан, тодруулгын маягт, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал”-ыг ашиглаж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хуульд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газар нь Засгийн газрын 2012 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 06 дугаар тогтоолоор байгуулагдсан. 9070003087 улсын бүртгэлийн дугаартай, 5635926 регистрийн дугаар бүхий 8790 кодтой, Хүн амын хөгжлийг дэмжих, нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлэх зөвшөөрлийн гэрчилгээтэй үйл ажиллагаа явуулж байна.

Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээнд тус ерөнхий газар нь 21 аймаг, 9 дүүрэг, нийслэл, БНСУ дахь НХҮТөв гэсэн 33 нэгжид Нийгмийн халамжийн тухай хууль тогтоомжийн биелэлтийг хангуулан ажилладаг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг юм.

Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газрын эрхэм зорилго нь Нийгмийн халамжийн тухай хууль, тогтоомжийн биелэлтийг хангуулан, үйлчлүүлэгчдэд ёс зүйтэй мэргэжлийн үйлчилгээг үзүүлэх замаар тэдний тэтгэвэр, тэтгэмж, тусламж, хөнгөлөлт авах, асрамж, халамжийн үйлчилгээнд хамрагдах таатай нөхцөлийг бүрдүүлэхэд оршдог.

Монгол Улсын хууль тогтоомжоор тогтоосон нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газрын зорилт, чиг үүргийг дараах зорилтын хүрээнд хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Хүн амын хөгжлийг хангах дэмжих төрийн бодлогын хэрэгжилтийг хангах;
- Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж үйлчилгээг зорилтот бүлэгт түргэн шуурхай хүнд сурталгүй чанартай хүргэх, халамж асрамжийн шинэ үйлчилгээ, менежментийг нэвтрүүлэх, ТББ болон хувийн хэвшлийн оролцоотойгоор үйлчилгээг чанартай хүргэх;
- Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын механизмыг боловсронгуй болгох;
- Төсвийн төлөвлөлтийн орон нутгийн хүн амын тоо, зорилтот бүлгийн иргэдийн тоотой уялдуулах, зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэх зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна;

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.5-д "агентлагийн дарга тус агентлагийн төсвийн шууд захирагч байна" гэж заасны дагуу Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газрын дарга Төсвийн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газрын 2015 оны төсвийг Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны Төрийн сангаас олгож байна.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газрын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газрын 2015 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн

санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 5-ыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газрын санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан 2014 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн мөрдөн ажиллаж байгаа ч УСНББОУС, хууль эрх зүйн өөрчлөлтийг тусган шинэчлэн батлуулах шаардлагатай байна.

Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газрын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газрын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөл бүхий санхүү, нягтлан бодох бүртгэлийн “Acolous” санхүүгийн програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Материаллаг байдлыг тодорхойлох:

Төсвийн тухайн хуулийн дагуу улсын төвлөрсөн төсвөөс санхүүждэг, төрийн байгууллага тул материаллаг байдлын суурийг тайлант оны нийт зардлаар авч, түүний 1 хувиар тооцож, /20,478.6 сая төгрөгийн нэг хувь/= 204.8 сая төгрөгөөр тогтоосон.

Дотоод хяналт:

Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын баталсан удирдамжийн дагуу 2015 оны 02 дугаар сарын 09-нөөс ажлын 10 өдөрт багтаан аудитын шалгалтын хийж гүйцэтгэсэн байна.

Дотоод аудитаар Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай, Нийгмийн халамжийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Шилэн данс тухай болон бусад холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт, 2014 оны санхүүгийн тайлан тэнцэл, төсөв төлөвлөгөө, хөрөнгө оруулалт, хүний нөөц, удирдлага зохион байгуулалт, тушаал, журам, албан хэрэг хөтлөлтийн стандарт зэргийг шалгаж үнэлэлт дүгнэлт өгч, 4 зөвлөмж өгсөн байна.

Зөвлөмжийн мөрөөр арга хэмжээ авч ХАХНХЯ-ны Хяналт-шинжилгээ үнэлгээ дотоод аудитын газрын Дотоод аудитын албанд холбогдох тайлбар, баримтын хамт хүргүүлж ажилласан байна.

Тус газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний газар нь төлөвлөгөөт хяналт шалгалтаар харъяа аймаг, нийслэл, дүүргийн Нийгмийн халамж үйлчилгээний газар, хэлтсүүдэд шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, зөрчлөөс урьдчилан

сэргийлэх талаар зөвлөмж, чиглэл хүргүүлж биелэлтэнд хяналт тавьж ажилласан байна. Нийт 29 нэгжид давхардсан тоогоор 213 заалт бүхий 23 зөвлөмжийг хүргүүлэн хяналт тавьж ажилласан байна.

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газрын дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

2015 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу салбарын яамны Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газрын төсвийн захирагч нь 2015 онд улсын төсвөөс 15,577.1 сая, туслах үйл ажиллагааны орлогоос 833.6 сая, нийт 16,410.7 сая төгрөгийн орлоготой ажилласан байна. Үүнээс урсгал зардалд 17,141.5 сая төгрөг батлагдсанаас 16,410.7 сая төгрөгийг зарцуулж, батлагдсан төсвийг 730.8 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Шилэн дансны мэдээлэл:

Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газар нь 2014-2016 онд “Шилэн данс”, “Шилэн тендер”-ийг санхүүгийн болон байгууллагын бүхий л үйл ажиллагаанд хэрэгжүүлэх зорилт тавьж амжилттай хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Шилэн дансны тухай хуулийн 2014 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн 26 дугаар хуулийн дагуу Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газрын даргын 2014 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 205 дугаар тушаал батлагдан холбогдох журам, заавар, төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.
- Тус байгууллага halamj.gov.mn вэб сайтад санхүүгийн холбогдох бусад мэдээллийг цаг хугацаанд нь байршуулах.
- Байгууллагын цахим хуудсаны Ил тод байдал цэсэнд санхүүгийн болон үйл ажиллагааны талаарх мэдээллийг тогтмол байршуулснаар олон нийт төсвийн зарцуулалт болон үйл ажиллагаанд хяналт тавих боломж бүрдүүлэх.
- Shilendans.gov.mn сайтад хуулинд заасны дагуу мэдээллийг хугацаанд нь шинэчлэн байршуулах.
- Шинээр мэдээллийн самбарыг хийлгэж байгууллагын 4 давхарт байршуулан санхүүгийн мэдээллийг 7-10 хоног тутам байршуулан ажилчид, иргэдийн зүгээс төсвийн зарцуулалтад хяналт тавих боломжийг бүрдүүлсэн байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 5 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 5 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газрын 2015 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн

гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний дүн бүхий дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газрын 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газар, аймаг нийслэл, дүүргийн Нийгмийн халамж үйлчилгээний хэлтсүүд болон БНСУ дах Нийгмийн хамгааллын үйчилгээний төв зэрэг 33 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна.

Аудитад нийт 33 байгууллага хамрагдаж 52.8 хувийг аймгийн аудитын газрууд, 39.4 хувийг аудитын компаниуд гэрээлэн, 7.8 хувийг санхүүгийн аудитын газар аудит хийж дүгнэлт гаргасан байна. Дорноговь аймгийн Нийгмийн халамж үйлчилгээний хэлтсийн 2015 оны санхүүгийн тайланд хязгаарлалтай дүгнэлт өгөгдөж, бусад байгууллагууд зөрчилгүй дүгнэлт авсан байна.

Аудитын явцад Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газарт мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлого, нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэж гаргах аргачлалын дагуу ажил гүйлгээг бүртгэлд тусгасан байдал, дансны болон ерөнхий журнал, ерөнхий дэвтэр зэрэг хураангуй бичилтийг арга зүйн хувьд нягтлан үзэж санхүүгийн тайлангийн илэрхийлэлд үнэлэлт өгсөн.

Санхүүгийн тайлан гаргалтын талаар:

Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газар 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан журам, аргачлалын дагуу бэлтгэж тайлагнасан байна.

2015 оны санхүүгийн тайлангаар 4.7 сая төгрөгийн мөнгөн хөрөнгө, 119.6 сая төгрөгийн авлага, 33.0 сая төгрөгийн өглөг, 791.0 сая төгрөгийн бараа материал, 7.0 сая төгрөгийн нөөцийн бараа, 20,804.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

Бараа материалын талаар:

Аудитаар төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 1,268.0 сая, малын нас дэвшилтийн орлого 24.2 сая, үнэ төлбөргүй хүлээн авсан 11.4 сая, орон нутгаас ахмадын сувилалд шилжүүлэн өгсөн 10.0 сая, дансны ангиллыг буруу бүртгэснийг залруулсан 6.1 сая, төрийн өмнөөс гүйцэтгэх ажил үйлчилгээний зардлаас модем бэлтгэсэн 4.7 сая, тооллогоор илэрсэн 0.8 сая, шатахууны картын урамшуулал 0.2 сая төгрөгийн бараа материалыг тус тус орлогод авч, худалдсан, зарцуулсан 1,172.6 сая, өмч хамгаалах комисс, даргын тушаалаар ашиглах боломжгүй хөрөнгийг актласан 26.0 сая, дансны ангиллыг буруу бүртгэснийг залруулсан 6.1 сая, малын нас дэвшилтийн хасалт 6.0 сая, үндсэн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэснийг аудитаар залруулсан 5.8 сая, бусад газарт шилжүүлсэн 1.7 сая төгрөгийн бараа материалыг тус тус хассан байна.

Үндсэн хөрөнгийн талаар:

Аудитаар дуусаагүй барилга байгууламжийг ашиглалтанд хүлээн авсан 3,496.6 сая, орон нутгийн санхүүжилтээр 1,905.5 сая, эрх шилжүүлсэн хөрөнгө оруулалтаар 400.0 сая, төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 164.7 сая, векселээр 164.1 сая, аудитын залруулгаар 9.8 сая, хөрөнгийн тооллогоор илрүүлсэн 8.5 сая, дэлхийн зөн олон улсын байгууллагын тусламжаар 1.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн орлого авч, дуусаагүй барилга байгууламжийг ашиглалтанд хүлээн авсан 3,496.6 сая, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолоор 402.5 сая, НӨХГ-ын даргын тушаалаар 269.0 сая, орон нутгийн өмчийн албаны 215.1 сая, ТӨХ-ны шийдвэрээр 107.3 сая, тушаал шийдвэргүй хассан 13.2 сая, Засаг даргын захирамжаар 8.5 сая, аймгийн НХҮХ-ийн даргын тушаалаар 3.0 сая, залруулсан 0.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг хассан байна

Мөн Орхон, Завхан, Говьсүмбэр, Дорноговь аймгийн Нийгмийн халамж үйлчилгээний хэлтсүүд анхан шатны баримтын бүрдэлгүй үндсэн хөрөнгийг орлогод авсан байна.

Орлогын талаар:

Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газар 2015 онд улсын төсвийн санхүүжилтийн 16,325.2 сая, нэмэлт санхүүжилтийн 3,872.7 сая, орон нутгийн төсвөөс санхүүжих 584.5 сая, төсвийн захирагчдаас 80.0 сая, нийгмийн даатгалын сангаас санхүүжих 28.1 сая, татварын бус орлогоос 993.1 сая төгрөгийг тус тус орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэлд тусган тайлагнасан байна.

Зардлын талаар:

Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газар 2015 онд үйл ажиллагааны зардалд 19,249.9 сая төгрөг байгаагийн 71.7 хувийг ажиллагсадтай холбогдсон зардал, 6.2 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал, 5.9 хувийг хангамж, бараа материалын зардал, 4.8 хувийг байр ашиглалтай холбоотой тогтмол зардал, 4.8 хувийг урсгал шилжүүлэг, 2.6 хувийг нормативт зардал, 1.8 хувийг томилолт, зочны зардал, 1.4 хувийг бараа үйлчилгээний бусад зардал, 0.8 хувийг урсгал засварын зардал, тус тус эзэлж байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар тус газар нь 2015 онд урсгал зардал 17,141.5 сая төгрөгөөр батлагдсанаас 16,410.7 сая төгрөгийг зарцуулж, 730.8 сая төгрөгийн хэмнэлттэй боловч зардлын ангиллаар урсгал засвар 10.4 сая, цалингийн нэмэгдэл 4.5 сая, тавилга 3.2 сая, БҮТЭЗ 2.5 сая, урамшуулал 1.7 сая төгрөгөөр тус тус хэтэрсэн байна.

Энэ нь Сангийн сайдын 2013 оны “Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн тухай” 73 дугаар журмын батлагдсан 2 дугаар хавсралтын дагуу бүлгийн дүнгээр хяналт тавих бараа үйлчилгээний зардлууд байна.

Авлагын талаар

Авлагын тодруулгаар 2015 онд авлага 40.1 сая төгрөгөөр нэмэгдэн 119.6 сая төгрөгт хүрсэн ба тооцоо нийлж баталгаажсан 101.1 сая, аудитын акттай 8.5 сая, найдваргүй авлага 10.0 сая төгрөгөөр тайлагнасан байна. Аудитаар 106.5 сая төгрөгийн авлага тооцоо нийлсэн буюу аудитын акттай байгаа нь нийт авлагын 89.0 хувь байна. Булган, Дархан, Орхон аймгийн НХҮХ-үүд авлагыг барагдуулах ажлыг зохион байгуулах, авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй Өмнөговь, Дорноговь аймгийн НХҮХ-ийн удирдлагатай хариуцлага тооцон ажиллах нь зүйтэй.

Өглөгийн талаар

Өглөгийн тодруулгаар 2015 онд өглөг 14.5 сая төгрөгөөр нэмэгдэн 33.0 сая төгрөг болж, ажилчидтай холбогдсон өглөг 12.5 сая, байгууллагад төлөх өглөг 10.3 сая, хувь хүмүүст төлөх өглөг 10.1 сая, бараа үйлчилгээний зардлын өглөгийг 0.1 сая төгрөгөөр тус тус тайлагнасан байна. Нийт өглөгийн 77 хувь буюу 12.3 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлж баталгаажуулсан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг хэмжээний алдаа илэрсэнгүй.

Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар

Материаллаг бус дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

1. 2015 оны санхүүгийн тайлангаа 2016 оны 3 дугаар сарын 04-ний өдөр 1/198 дугаар албан бичгээр УАГ-т ирүүлсэн байна. Тус санхүүгийн тайланд байгууллагын үйл ажиллагаанд чухал нөлөө үзүүлсэн томоохон үйл явдлын тухай тодруулга, тайлбар ирүүлээгүй байгаа нь УСНББОУС-1 стандартын санхүүгийн тайлагналын чанарын шинжүүд хавсралт А-д “Нягтлан бодох бүртгэлийн бодлого түүний чанарын шинж төрх байдлыг багтаасан байгууллагын мэдээллийг танилцуулах шаардлагыг энэ стандартын 29 дүгээр зүйлд тусгасан”, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 3 дугаар хавсралтын “төсөвт байгууллагын санхүүгийн тайлан бэлтгэх заавар”-ын 8 дугаар зүйлийн 8.1-д “Санхүүгийн тайлангийн тэмдэглэл тодруулга нь санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлтийн тайлангийн нүүрний хэсэгт харуулсан дүнгүүдийн талаар хүүрнэсэн тодорхойлолт, эсвэл нилээд дэлгэрэнгүй жагсаалт буюу судалгаа, мөн болзошгүй өр төлбөр болон амлалт гэх мэт нэмэлт мэдээллийг багтаана”, 8.4-д “жилийн эцсийн санхүүгийн тайлан бүрэн тодруулгатай, улирлын тайлан зөвхөн өр авлагын талаар тодруулгатай байна” гэсэнтэй тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: УСНББОУС-1 стандарт болон Сангийн сайдын 388 дугаар тушаалыг мөрдөж ажиллах талаар зөвлөмж өгөх;

2. 2015 оны нэгтгэсэн тайлан ирүүлэхдээ санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгө ба авлагын үлдэгдэл 11.2 сая, нийт өглөг 0.2 сая, хуримтлагдсан үр дүн 11.0 сая, санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны нийт үр дүн 11.0 сая, төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр 0.7 сая төгрөгөөр тус тус зөрүүтэйгээр тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйл, Нягтлан бодох бүртгэлийн зарчим 4.1-д. “Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлд дараахь зарчмыг баримтална”, 4.1.1-д “аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцсэн байх” 4.1.2-д “санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэх”, санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлийн 4-т “Иж бүрэн байх: аж ахуйн нэгж, байгууллага тайлант хугацаанд гарсан бүх ажил гүйлгээ, үлдэгдэл буюу үйл явдал, нөхцөл байдлуудаас бүртгээгүй, нэмж тодруулаагүй, орхигдуулсан зүйлсгүй байх” гэсэн УСНББОУС-6, батламж мэдэгдэлтэй тус тус нийцэхгүй байна;

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулга хийж, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС-6, батламж мэдэгдэлийг мөрдөж ажиллах талаар зөвлөмж өгөх;

3. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолоор 402.5 сая, НӨХГ-ын даргын тушаалаар 269.0 сая, Орон нутгийн өмчийн албаны шийдвэрээр 215.1 сая, ТӨХ-ны шийдвэрээр 107.3 сая, Дорноговь аймгийн НХҮХ тушаал шийдвэргүй хассан 13.2 сая, Засаг даргын захирамжаар 8.5 сая, аймгийн НХҮХ-ийн даргын тушаалаар 3.0 сая, нийт 1,018.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг актлаж, бусдад шилжүүлж, худалдсан байна.

Үндсэн хөрөнгийн хөдлөл хийсэн байгууллагуудаас 17 НХҮХ-үүдийн хөрөнгийг хассан дүн шийдвэрийн дүнтэйгээ зөрүү байгаа ба хуримтлагдсан элэгдлийн дүн, үлдэх өртөг 102.0 сая төгрөгөөр зөрүүтэй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 1-д "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна" 2-т "Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна" гэсэнтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үлдэх өртөгийг тохируулах, тушаал шийдвэргүйгээр үндсэн хөрөнгийг данснаас хасахгүй байх, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн мөрдөж ажиллах талаар албан шаардлага хүргүүлэх.

4. Багануурын НХҮХ уралдаан тэмцээнд 453.0 мянган төгрөг, эмэгтэйчүүдийн баяраар хүндэтгэл үзүүлэхэд 225.0 мянган төгрөгийг, Налайхын НХҮХ мэндчилгээ, мэдээ, мэдээлэлд 497.5 мянган төгрөгийг үр ашиггүй зарцуулсан нь Засгийн газрын 2014 оны "Төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлэх зарим арга хэмжээний тухай" 147 дугаар тогтоолын 4-д. "Яам, агентлаг, төсөвт байгууллагууд төв, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан төсвийн хөрөнгөөр олон нийтэд зайлшгүй мэдээлэх хууль тогтоомж, албан ёсны шийдвэр болон тэдгээрийн хэрэгжилтийг сурталчлан таниулахаас бусад зорилгоор өөрийн байгууллага, хамт олныг рекламдах, телевизийн шоу уралдаан, тэмцээн зохион байгуулах, цуврал олон ангит кино хийхгүй бөгөөд баяр ёслол, байгууллага, салбарын ой, тэмдэглэлт өдөр зохион байгуулахтай холбогдуулан төсвийн хөрөнгөөр цаасан мэндчилгээ илгээх, бэлэг дурсгалын зүйлс, цүнх, календарь зэрэг зүйлс бэлтгэх, ивээн тэтгэхийг хориглосугай" гэж заасантай,

Налайхын НХҮХ салбарын ажилтнуудыг чадваржуулах сургалтын зардалд анхан шатны баримтын бүрдэлгүйгээр 3,550.0 мянган төгрөг зарцуулж, томилолтын тооцоо хийгээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д "Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг, бүртгэл тайланд тусгахыг хориглоно" заалт, Засгийн газрын 2014 оны 147 тоот "Төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлэх зарим арга хэмжээний тухай" тогтоолын 3.7-д "Хурал, сургалт, зөвлөгөөний давтамжийг багасгах, зайлшгүй хийх тохиолдолд төлөөлөгчдийн тоог цөөн оновчтой, богино хугацаанд хийхээр, эсхүл цахим хэлбэрээр зохион байгуулах" гэж заасныг тус тус зөрчсөн байна;

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 147 тогтоолыг мөрдөж ажиллах талаар зөвлөмж өгөх;

5. Сэлэнгийн НХҮХ хоол унааны хөнгөлөлтийг батлагдсан төсвөөс 5,207.9 мянган төгрөгөөр хэтрүүлж, үндсэн цалингаар тайлагнасан, Төв аймгийн НХҮХ Төрийн санд хүсэлт гарган түлш халаалтын зардлаас урсгал засварын зардалд 7,448.0 мянган төгрөгийг гүйлгэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2-д "батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргах", Налайхын НХҮХ сургалтанд хамрагдсан ажиллагсдад өдрийн цайны мөнгө 450.0 мянган төгрөг зарцуулалт бусаар, Завханы НХҮХ түлш халаалтын зардлын 2,878.3 мянган төгрөгийг бусад бараа үйлчилгээний зардалд гүйлгэн зарцуулсан, шуудан

холбоо, БҮТЭЗ, хоол, урсгал засварын зардлуудын 1,195.8 мянган төгрөгийг гүйлгэсэн, Ховдын НХҮХ түлш халаалтын хэмнэгдсэн зардлаас хоолны зардлыг гүйлгэн гаргасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, “Өрхийн мэдээллийн сангийн хэрэглээ” сургалтанд ХУД-ийн НХҮХ-ийн 36 ажилтан хамрагдсанд нийт 180.0 мянган төгрөгийн хоолны мөнгө олгосон нь цалингийн нэмэгдлээр олгогдсон тухайн өдрийн хоолны мөнгөтэй давхцсан, Багануурын НХҮХ уралдаан тэмцээнд 453.0 мянган төгрөг, эмэгтэйчүүдийн баяраар хүндэтгэл үзүүлэхэд 225.0 мянган төгрөгийг үр ашиггүй зарцуулсан, Нийслэлийн НХҮХ Үйл ажиллагааны бус /смарт карт шимтгэлийн орлого/ орлогоос 4,710.5 мянган төгрөгийг өмнөх оны аудитаар илэрсэн ажиллагсдаас суутган төлөх актын төлбөрт төлсөн, Баянхонгорын НХҮХ төсвийн захирагчийн нэр дээр байгаа гар утасны төлбөр 71.5 мянган төгрөгийг байгууллагаас төлж төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, Дундговийн НХҮХ-ийн 24 ажиллагсдыг албан томилолтоор ажилласан үед 397.2 мянган төгрөгийн хоолны мөнгө давхардуулан олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” заалтыг тус тус зөрчиж байна;

Шийдвэрлэсэн нь: Төсвийн төлөвлөлтийг бодитой мэдээ, тооцоо, судалгаанд үндэслэн хийж, бодит бус хэтрэлт, хэмнэлтийг үүсгэхгүй, үр ашиггүй зардал гаргахгүй байхад анхаарч ажиллах талаар зөвлөмж өгөх;

6. Хэнтийн НХҮХ МЦХ ТӨХК–д илүү шилжүүлсэн ярианы төлбөр 151.6 мянган төгрөгийг авлагыг, ГовьСүмбэр аймгийн НХҮХ 23.9 мянган төгрөгийн ХХОАТ-ын өглөгийг, ХГБХХ-ийн түрээс төлбөр 249.5 мянган төгрөгийн авлагыг, Хан Уул дүүргийн НХҮХ 2014 оны жилийн эцсийн “УБЦТС” ТӨХК-иас авах 29.4 мянган төгрөгийн авлагыг тус тус санхүүгийн тайланд тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө” гэсэн заалтыг зөрчсөн байна;

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС-ийг мөрдөж ажиллах талаар зөвлөмж өгөх;

Аймгийн аудитын газар болон гэрээгээр аудит хийсэн аудитын компаниудын хийсэн аудитаар материаллаг бус дараах зөрчил илэрсэнийг жагсаавал:

Сэлэнгэ аймгийн НХҮХ

- 4.0 сая төгрөгийн худалдан авсан хаш чулуун орыг орлогоор бүртгээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д “аж ахуйн нэгж байгууллага нь хөрөнгө өр төлбөрөө НББОУС-ын дагуу үнэлж дансанд тусгана” дэх заалтыг зөрчсөн.
- Өртгөө бүрэн нөхсөн цаашид ашигдах боломжгүй 71.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг актлаж данснаас хасахдаа 689.2 мянган төгрөгийн элэгдэл байгуулж элэгдлийн хэмжээгээр үндсэн хөрөнгө данснаас хассан гарзаар бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1-д “анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно” НХҮБ-ын НБББББ-ийн 3.1.6.-д “элэгдлээрээ анхны өртгөө нөхөөгүй үндсэн хөрөнгийг данснаас хасвал Дт хуримтлагдсан элэгдэл, Кт үндсэн хөрөнгийг хассан гарз, үндсэн хөрөнгө”
- Цалингийн санг 368.9 мянган төгрөгөөр дутуу тусгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1-д “анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”

Төв аймгийн НХҮХ

- Тооллогын комиссууд үндсэн хөрөнгийн тооллогын дүнг нэгтгэж гаргаагүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72.4.4-д “тооллогын комиссийн хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж холбогдох акт материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх”
- Байгууллагын тооллогын комисс нь бичиг хэрэг, шатахуун, аж ахуйн материал 23,598.8 мянган төгрөгийн эргэлтийн хөрөнгөнд тооллого хийгээгүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72.4.1-д “тооллогын комисс эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах”
- Барилгын засварын материалын үнэнд 4,384.5 мянган төгрөгийг зарцуулахдаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7.5-д “Анхан шатны баримтанд түүнийг үйлдсэн зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг, тамга тэмдэг дарсанаар уг баримт хүчин төгөлдөр болно”

Дархан Уул аймгийн НХҮХ

- Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай 354 дугаар тогтоолыг зөрчсөн
- Нэмэлт санхүүжилтээр хийгдсэн баталгаажуулалт, судалгааны гэрээт ажилчдын цалингаас 94.6 мянган төгрөгийн ХХОАТ суутгаагүй.

Орхон аймгийн НХҮХ

- Хөдөлмөрийн биржийн данснаас 1997 онд Сэргээн босголтын банкинд төвлөрүүлсэн 336.3 мянган төгрөг, 2012 онд Хадгаламж банкинд шилжүүлсэн 84.0 мянган төгрөгийг авлагаар бүртгээд авч чадаагүй

ГовьСүмбэр аймгийн НХҮХ

- Ажиллагсдын ээлжийн амралтын болон ажилласан хугацааны цалинг давхардуулан 297.4 мянган төгрөг олгосон
- 3,376.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бараа материалд бүртгэсэн

Хан Уул дүүргийн НХҮХ

- Тайлант онд 4,798.5 төгрөгийн бараа материалыг акталсан бөгөөд бараа материал акталсан зардал дансанд бүртгэлгүй бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлсийн зарцуулалтын дансанд бүртгэсэн байна.
- Бараа материалын дансанд 5,808.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн шинжтэй дараах зүйлс бүртгэгдсэн байна. Үүнд: Үйлчилгээний танхимын хаалт, сурталчилгааны майхан, электрон самбар
- Урсгал зардлыг бүлэг хооронд шилжүүлэн зарцуулахдаа Сангийн сайдын 73 тушаал “Төсөвт зохицуулалт хийх журм”-ын дагуу харьяа төрийн санд хүсэлт гаргаж бүлэг хооронд зохицуулалт хийлгүйгээр батлагдсан төсвийг зориулалтын бус зарцуулсан байна. Үүнд: Даатгалын зардлын төсвөөс 110.5 мянган төгрөгийн машины сэлбэг хэрэгсэл, цалин хөлсний зардлын төсвөөс 100.0 мянган төгрөгийн шагнал олгосон
- Тээвэр шатахууны зардалд 1,260.5 мянган төгрөгийн машины сэлбэг хэрэгслийг, бичиг хэргийн зардалд 915.0 мянган төгрөгийн шуудан холбооны зардлыг тусгаж зардлын ангилал буруу бүртгэжээ.
- “Өрхийн мэдээллийн сангийн хэрэглээ” сургалтанд ХУД НХҮХ-ийн 36 ажилтан хамрагдсанд нийт 180.0 мянган төгрөгийн хоолны мөнгө олгосон нь цалингийн нэмэгдлээр олгогдсон тухайн өдрийн хоолны мөнгөтэй давхацсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д “Төсвийн үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах” заалтыг зөрчиж байна.
- Тус байгууллагын 2 мэргэжилтэнд 50 нас хүрсэнд хүндэтгэл үзүүлж Хөдөлмөрийн дотоод журмын 7.5.1, 7.5.4 заалтыг үндэслэн даргын тушаалаар нийт 250.0 мянган төгрөгийн тэтгэмж олгосон нь Засгийн газрийн 1995 оны 96 дугаар тогтоолын 6-р хавсралтын “Төрийн байгууллагад тогтвор суурьшил, үр бүтээлтэй, олон жил (10-аас доошгүй жил) ажилласан төрийн албан хаагчид насны ой, тэмдэглэлт үйл явдлыг тохиолдуулан болон гэр бүл болоход нь байгууллагын

захиргаанаас 50,000 хүртэлх төгрөгийн үнэ бүхий эд зүйлийг дурсгаж болно” заалтыг зөрчиж илүү 150.0 мянган төгрөг зарцуулсан байна.

- 2016 онд НӨХГ-ын шийдвэрээр үндсэн хөрөнгийг актлахдаа 2009 онд дахин үнэлэгдсэн хөрөнгүүдийн дахин үнэлгээний нэмэгдлийн дүнг буруу тооцоолж 20.2 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна. Мөн 2009 онд дахин үнэлсэн хөрөнгөтэй тайлант оны хөрөнгүүдийг тулган үзэхэд 8 төрлийн хөрөнгийг өмнөх жилүүдэд актлахдаа дахин үнэлгээний нэмэгдлийг 514.5 мянган төгрөгөөр бууруулаагүй байна.
- Ажиллагсдад олгосон түлээ нүүрсний үнийн хөнгөлөлтөөс 364.4 мянган төгрөг, 15 хүнтэй хөлсөөр ажиллах гэрээ байгуулан олгосон ажлын хөлсөөс 130.2 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл суутган тооцоогүй нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 32-т. Нийгмийн даатгалийн шимтгэл ногдуулах хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлого 32.4-т “Аж ахуйн нэгж, байгууллагаас ажилтанд олгож байгаа хоол, унааны зардал, орон сууц түлээ нүүрсний үнийн хөнгөлөлт, түүнтэй адилтгах бусад орлого” “Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан гэрээгээр тохирсон хөлс” заалтыг зөрчсөн байна.

Чингэлтэй дүүргийн НХҮХ

- Мөнгөн гүйлгээний тайланд ХЧТАТ, жирэмсэн ба хүүхэд төрүүлсний тэтгэмж 11,513.7 мянган төгрөг /харилцах дансанд орсон/-өөс 317.8 мянган төгрөгийг мөнгөн гүйлгээний тайланд тайлагнаж 11,195.9 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан нь УСНББОУС 2.32-т. дараах үйл ажиллагаанаас үүссэн мөнгөн гүйлгээг цэвэр сууриар тайлагнаж болно.а/ Мөнгөн гүйлгээ нь тухайн байгууллагын үйл ажиллагааны бус харин бусад талын үйл ажиллагааг тусгаж байгаа худалдан авагч, татвар төлөгч болон тэтгэмж хүлээн авагчийн нэрийн өмнөөс төлсөн мөнгөн төлбөр болон цуглуулсан мөнгөн орлогыг заалт Сангийн сайдын 2008 оны 352 тоот тушаалын 26-д “ё” Хөдөлмөрийн чадвараа түр алдсан ба жирэмсэн эхийн тэтгэмжийн мөнгийг НД-ын газраас авахаар тооцсон үед дараахь дансны бичилтийг хийнэ.”ДТ НДБ-аас авах авлага, КТ Цалингийн тооцооны өглөг” гэж нэмсүгэй гэсэн заалттай нийцэхгүй байна.
- ХХОАТ төлөхөөр тооцоолсон цалин нь хөдөлмөрийн хөлс тэдгээртэй адилтгах орлогын татварын тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлангаас 1,931.2 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан. Энэ нь татварын ерөнхий хуулийн 18.1.6-д “бусдад олгох хөдөлмөрийн хөлс, шилжүүлсэн орлогод ногдох татварыг үнэн зөв суутган тооцож” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Сүхбаатар дүүргийн НХҮХ

- Үндсэн хөрөнгөнд 2,275.0 мянган төгрөгийн бүртгэлтэй Бенз маркийн суудлын автомашин биетээр байхгүй, өмнөх аудитаар эзэн холбогдогчийг нь тогтоон холбогдох газраар шийдвэрлүүлэх тухай албан шаардлага хүргүүлсэн ч өнөөг хүртэл шийдвэрлээгүй байна.

Багахангай дүүргийн НХҮХ

- Цалингийн зардлыг Санхүүгийн үр дүнгийн тайлан 882.0 мянган төгрөгөөр илүү тусгасан нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэлийн дансны заавар –ын 4.2.1-д санхүүгийн тайлан нь үнэн зөв баримт материал, бодит тоон мэдээнд үндэслэх гэсэн заалтыг зөрчиж байна.

Нийслэлийн НХҮХ

- Үйл ажиллагааны бус орлого 26,412.9 мянган төгрөгийн орлого бууруулах бичилт хийсэн нь, Нягтлан бодох бүртгэлийн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “аж ахуйн нэгж, байгууллага, нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө” гэж заасантай нийцэхгүй байна.

Архангай аймгийн НХҮХ

- Хоолны зардалд 154.2 мянган төгрөг, түлш халаалтын зардалд 6,361.6 мянган төгрөгийг тус тус тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардлаар бүртгэж тайлагнасан нь Сангийн сайдын 2008 оны 388-р тушаалын 1-р хавсралын 4.21 дэх заалттай нийцэхгүй байна.

Баянөлгий аймгийн НХҮХ

- Тайлант онд гарсан ажилчдын цалингаас суутгасан 407.3 мянган төгрөгийн ХХОАТ-ыг төсөвт дутуу төвлөрүүлж ХХОАТ-ын тухай хуулийн 26.1.2-т заасан “Ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин нэмэгдэл хөлс, шагнал урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр тэтгэмж тэдгээртэй адилтгах бусад орлогод албан татварыг сар бүрийн эцэст ногдуулж, мөн хуулийн 24.1-д заасан хөнгөлөлтийг хасч холбогдох төсөв шилжүүлэх” гэсэн заалыг хэрэгжүүлээгүй.

Баянхонгор аймгийн НХҮХ

- Аудитын шалгалтаар 2015 оны санхүүгийн тайлангаар 440.0 мянган төгрөгийн хоолны мөнгөнөөс 44.0 мянган төгрөгийн ХХОАТ тооцоогүй байна.
- Мөн төсвийн захирагчийн нэр дээр байгаа гар утасны төлбөр 71.5 мянган төгрөгийг байгууллагаас төлж төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан.

Говьалтай аймгийн НХҮХ

- Шатахууны тооцоог давтан тооцож үзэхэд албан ажлын машиныг дотор үйлчилгээнд хэрэглэж 148,5 мянган төгрөгийн шатахууныг зарцуулсан.

Дорноговь аймгийн НХҮХ

- Эд хариуцагчийн тайлагнасан бараа материалын тайлангийн зарим дансны эхний үлдэгдэл, санхүүгийн тодруулга тайлан дах бараа материалын тайлангийн зарим дансдын эхний үлдэгдэл 16.2 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн.
- НХҮЕГ-аас олгосон Өрхийн орлогыг орлуулан тооцох судалгааны дахин үнэлгээ, баталгаажуулалтын зардал болох 38.8 сая төгрөгөөс зарцуулаагүй үлдсэн 8.9 сая төгрөгийг санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй байна.
- Төсвийн хөрөнгөөр авсан 374.0 мянган төгрөгийн өртөгтэй эд хариуцагчийн програмыг данс бүртгэлд тусгаагүй байна.
- Тайлант онд ажилчдад урьдчилгаа цалин олгоод 750.0 мянган төгрөгийг суутгаагүй байна. Мөн 2 ажилчны урьдчилгаа цалинг 117.5 мянган төгрөгөөр илүү суутгасан.
- Ахмад настанд зориулан ажиллуулдаг сувилалын орлогоос 880.0 мянган төгрөгийг байгууллагын харилцах данс болон касст дутуу төвлөрүүлсэн байна.

Дорнод аймгийн НХҮХ

- Цалингийн болон хүнсний материалын 411.1 мянган төгрөгийн авлагыг хаахдаа зардал бууруулах бичилт хийсэн нь Төсвийн тухай хуулийн 6.3.1 дэх “Төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийн гүйлгээг бууруулах бичилт хийхгүйгээр нийт дүнгээр нь төлөвлөж тайлагнах” гэж заасантай нийцэхгүй байна.
- Хуучин эвдэрсэн, олон жил болсон, шаардлага хангахгүй 4,461.0 мянган төгрөгийн материал дансанд бүртгэлтэй байна.

Дундговь аймгийн НХҮХ

- 2015 онд хэрэгжсэн Өрхийн мэдээллийн сангийн мэдээллийн баталгаажуулах үйл ажиллагаанд машин хөлсөөр ажиллаж 9916 км явсан байна. Замын хуудсыг холбогдох удирдах ажилтнуудаар баталгаажуулаагүй байна. Анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар 2,380.3 мянган төгрөгийн зардал гаргасан нь НББ-ийн тухай хуулийн 7.5 дах заалтыг зөрчсөн байна.

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газрын 2015 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газрын 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 55,408.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба үүнээс 2.3 сая төгрөгийн 8 төлбөрийн акт, 294.2 сая төгрөгийн 3 албан шаардлага тавьж, 153.8 сая төгрөгийн 44 зөвлөмж өгч, 54,958.0 сая төгрөгийн 14 зөрчлийг аудитын явцад залруулав.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн 2014 оны санхүүгийн тайланд Үндэсний аудитын газраас хийсэн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй болно.

Зөвлөмж

Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газрын 2015 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар санхүүгийн тайлагнал, төсвийн зарцуулалт, авлага, өглөгийн талаар 5 зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газрын 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 8 хуудас, хавсралтууд.... хуудас, байгууллагын санал .. хуудсыг тус тус хавсаргав.



НИЙГМИЙН ХАЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2015 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар харилцана уу:

Санхүүгийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор С.Энхзаяа
Утас: 261663
Цахим хаяг: enkhzayas@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Гүнжидмаа
Утас: 261885
Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Цэрэндорж
Утас: 261740
Цахим хаяг: tserendorjd@audit.gov.mn

Менежментийн захидал

Асуудал 1 Санхүүгийн тайлагналын
талаар

Асуудал 2 Санхүүгийн тайлагналын
талаар

Асуудал 3 Төсвийн зарцуулалтын
талаар

Асуудал 4 Төсвийн зарцуулалтын
талаар

Асуудал 5 Авлага, өглөгийн талаар

ТАБ-ын хаяг: Үндэсний аудитын
газар

Байршил: Чингэлтэй дүүрэг

Цахим хуудас: www.audit.mn

2016 оны 3 дугаар сар

Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газрын удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал буюу горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг Үндэсний аудитын газрын аудитын горимоос урган гарсан. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан болно. Энэ нь Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газрын хэрэгжүүлдэг нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянах бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Үндэсний аудитын газар энэхүү зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газрын Санхүү бүртгэл, төлөвлөлтийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Гандолгор, үйл ажиллагаа хариуцсан мэргэжилтэн Г.Оюун, санхүүгийн бусад ажилтнуудад талархал илэрхийлье.

ҮАГ-ын ажиглалт

